



**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/127.

Улаанбаатар хот

Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн "Тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн үзүүлэлт батлах, эрх шилжүүлэх тухай" А/377 дугаартай тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвд eHealth цахим систем нэвтрүүлэхтэй холбоотой мэдээллийн аюулгүй байдал, сүлжээний аюулгүй ажиллагаа, цахим эмнэлэг болох ажлын хүрээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, дагалдах сэлбэг хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах "Үнэлгээний хороо"-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:

Д.Баярсайхан – Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал

Нарийн бичгийн дарга:

А.Шинэхүү – Эдийн засагч

Гишүүд:

Н.Батням – Хангамж үйлчилгээ, инженер техникийн албаны дарга

Д.Жаргалсайхан – Соёл үйлчилгээний албаны дарга

Ц.Батзаяа – Чанарын менежер

Н.Батжаргал – Худалдан авах ажиллагааны хөтөч ТББ-ын багш /зөвшилцсөнөөр/

Б.Энх-Амгалан – Анарваан домч ТББ-ын тэргүүн /зөвшилцсөнөөр/

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.2 дахь хэсэгт заасны дагуу eHealth цахим систем нэвтрүүлэхтэй холбоотой мэдээллийн аюулгүй байдал, сүлжээний аюулгүй ажиллагаа, цахим эмнэлэг болох ажлын хүрээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, дагалдах сэлбэг хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулахад нийтийн албаны болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, холбогдох хууль дүрэм журмыг чанд мөрдөж ажиллахыг тендерийн үнэлгээний хорооны дарга (Д.Баярсайхан)-д даалгасугай.
3. Худалдан авах ажиллагаанд баримтлах хууль тогтоомжийн мэдээллээр хангах, тендерийн үнэлгээний баримт бичиг эмхлэх, архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (А.Шинэхүү)-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Л.БАТТӨР